ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2025/048/-НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Зуунмод 2025 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582  Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463  Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор  С.Намшир

Утас: 70273465  Цахим хаяг: namshirs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/141
танай ____________-ны № ________________-т

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГАНТӨМӨР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 онд ЕБС-ийн спорт заалны барилгын ажлыг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2022 оноос Хабул констракшн ХХК-тай 2,099.4 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Сумын ИТХ-р 328.4 сая төгрөг нэмж баталж, үнийн зөрүү гэсэн нэмэлт гэрээ байгуулж олгосон. Үнийн зөрүүний тооцооллыг гүйцэтгэгч компани өөрөө гаргасан бөгөөд ямар нэг хөндлөнгийн хяналт, магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй, батлагдсан зураг төсөлгүй олгосон, Баянгийн үдэш арга хэмжээнд 1,204.6 мянган төгрөг, спортын уралдаан тэмцээнд 1,388.5 мянган төгрөг, нийт 2,593.1 мянган төгрөгийг зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", $29^1$.2.2-д "барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд

хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв

412505368

нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ", Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Засаг даргын Тамгын газар нь сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах, оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго тавьж ажиллажээ. Тайлант онд сумын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан 2,075,120.4 мянган төгрөгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг улс, орон нутгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Төв аймгийн Баян сумын ЗДТГ-аас тайлант онд Спортын заал барих ажилд Хабул констракшн ХХК-тай гэрээ байгуулан 765,787.9 мянган төгрөг, Төрийн албан хаагчийн орон сууц барих ажилд Нью престиж констракшн ХХК-тай гэрээ байгуулан 60,983.7 мянган төгрөг, ЗДТГ-ын засварын ажилд Ньютерра вокс ХХК-тай гэрээ байгуулан 119,949.3 мянган төгрөг, Сумын төвийн засмал замын ажилд Хишигбуянт зам ХХК-тай гэрээ байгуулан 494,192.9 мянган төгрөг, Далангийн ажилд Ноён гэгээ ХХК-тай гэрээ байгуулан 66,878.9 мянган төгрөг, Шугам сүлжээний ажилд Арбулаг ХХК-тай гэрээ байгуулан 65,766.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж гүйцэтгүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Баян сумын ИТХ-аас 2024 оныг "Залуучуудын манлайлал, гэр бүлийн хөгжил"-ийг дэмжих урианы жил болгон зарласан байна. Урианы жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 76,0 хувиар биелүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **526,189,428.6** | **1,394,549,636.4** |
| **33** | **АВЛАГА** | **442,425,735.0** | **1,324,647,011.8** |
| 335 | Бусад авлага | 442,425,735.0 | 1,324,647,011.8 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 442,425,735.0 | 1,324,647,011.8 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **83,763,693.6** | **69,902,624.6** |
| 351 | Түүхий эд материал | 3,254,101.8 | 3,525,901.8 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,051,461.8 | 1,860,261.8 |
| 35130 | Эм боох материал | 1,202,640.0 | 1,665,640.0 |
| 354 | Хангамжийн материал | 67,359,591.8 | 64,826,722.8 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,555,890.0 | 2,961,080.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 51,396,201.8 | 53,344,342.8 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,904,000.0 | 2,754,000.0 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.0 | 400,000.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,503,500.0 | 5,367,300.0 |
| 35600 | Мал амьтад | 13,150,000.0 | 1,550,000.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,861,318,834.2** | **4,343,799,271.5** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,861,318,834.2** | **4,343,799,271.5** |
| 392 | Биет хөрөнгө | 2,160,655,834.1 | 3,636,738,771.3 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,793,742,809.8 | 2,806,336,949.8 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,736,863,083.7 | -1,803,645,285.2 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 243,864,598.0 | 177,078,600.0 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -165,803,775.7 | -120,199,211.0 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 161,077,985.3 | 187,198,447.2 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -70,643,245.1 | -90,039,733.7 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 49,152,353.2 | 66,529,158.2 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -33,680,088.0 | -33,815,353.4 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 0.0 | 1,809,595,963.0 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1,103,850.0 | 1,103,850.0 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 817,930,991.7 | 919,039,563.1 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -196,765,909.5 | -282,444,176.8 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 297,539,348.0 | 0.0 |
| 393 | Биет бус хөрөнгө | 700,663,000.1 | 707,060,500.2 |
| 39301 | Програм хангамж | 7,342,500.0 | 10,342,500.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -6,137,499.9 | -2,739,999.8 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 699,458,000.0 | 699,458,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,387,508,262.8** | **5,738,348,907.9** |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,453,470.0** | **1,391,057.0** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,453,470.0** | **1,391,057.0** |
| 413 | Өглөг | 1,453,470.0 | 1,391,057.0 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,453,470.0 | 0.0 |
| 4136 | Бусад өглөг | 0.0 | 1,391,057.0 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.0 | 1,391,057.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,386,054,792.8** | **5,736,957,850.9** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,386,054,792.8 | 5,736,957,850.9 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,262,355,725.4 | 1,262,355,725.4 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,262,355,725.4 | 1,262,355,725.4 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,162,107,616.4 | 3,513,879,948.6 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,162,107,616.4 | 1,162,976,890.5 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 2,350,903,058.1 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 961,591,451.1 | 960,722,177.0 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,387,508,262.8** | **5,738,348,907.9** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,259,104,054.8** | **6,938,185,396.6** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **317,126,564.0** | **1,910,192,421.9** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 317,126,564.0 | 1,910,192,421.9 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 317,126,564.0 | 1,910,192,421.9 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 317,126,564.0 | 1,910,192,421.9 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,941,977,490.8** | **5,027,992,974.6** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 213,566,990.8 | 789,729,874.6 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 0.0 | 3,000,000.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.0 | 83,141,444.5 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 166,815,146.9 | 514,741,425.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 46,751,843.9 | 188,847,005.1 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,728,410,500.0 | 4,238,263,100.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,728,410,500.0 | 4,238,263,100.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,585,921,202.2** | **4,238,953,584.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,522,064,284.2** | **3,611,602,320.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **781,760,199.4** | **1,106,152,455.8** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 407,305,769.5 | 550,901,618.9 |
| 210101 | Үндсэн цалин | 280,765,280.6 | 324,212,181.3 |
| 210102 | Нэмэгдэл | 85,975,893.1 | 214,036,157.7 |
| 210104 | Урамшуулал | 40,564,595.8 | 12,653,280.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,532,641.3 | 66,402,483.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,995,084.1 | 45,975,756.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,117,068.7 | 5,502,624.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,289,255.0 | 3,186,213.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 735,850.2 | 2,341,531.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,395,383.2 | 9,396,358.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 61,551,096.6 | 70,614,004.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,246,150.6 | 9,482,596.2 |
| 210302 | Түлш, халаалт | 52,304,946.0 | 61,131,408.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 36,786,099.1 | 43,263,349.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,289,930.0 | 2,627,710.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,057,670.0 | 24,573,910.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,060,000.0 | 1,100,450.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,228,699.1 | 8,955,280.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 149,800.0 | 158,700.0 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,000,000.0 | 5,847,299.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,924,100.0 | 1,821,600.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,924,100.0 | 1,821,600.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,814,000.0 | 5,838,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,814,000.0 | 5,838,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,566,389.0 | 6,843,565.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,800.0 | 2,141,490.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.0 | 1,612,800.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 246,900.0 | 273,825.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 486,790.0 | 370,900.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 124,000.0 | 143,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,691,899.0 | 2,301,550.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 215,280,103.9 | 360,467,835.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,267,067.5 | 115,104,622.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 185,013,036.4 | 245,363,213.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **740,304,084.8** | **2,505,449,864.5** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,181,100.0 | 23,369,976.7 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 0.0 | 5,757,700.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,791,100.0 | 0.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.0 | 14,892,277.5 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 390,000.0 | 2,719,999.2 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 723,188,432.0 | 2,482,014,711.9 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 723,188,432.0 | 2,482,014,711.9 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 934,552.8 | 65,175.9 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 934,552.8 | 65,175.9 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **63,856,918.0** | **627,351,264.0** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 63,856,918.0 | 627,351,264.0 |
| 220001 | Барилга байгууламж | 0.0 | 601,071,864.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 29,500,000.0 | 0.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 34,356,918.0 | 26,279,400.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **673,182,852.6** | **2,699,231,812.2** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0.0** | **348,328,754.1** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.0 | 7,177,829.2 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 0.0 | 341,150,924.9 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **0.0** | **-348,328,754.1** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **673,182,852.6** | **2,350,903,058.1** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,941,977,490.76** | **5,044,892,274.63** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,941,977,490.76** | **5,044,892,274.63** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 213,566,990.76 | 806,629,174.63 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 83,141,444.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 166,815,146.90 | 514,741,425.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 46,751,843.86 | 205,746,305.13 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,728,410,500.00 | 4,238,263,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,728,410,500.00 | 4,238,263,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,327,422,837.76** | **3,309,104,753.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,327,422,837.76** | **3,309,104,753.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **586,518,452.96** | **803,774,889.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 407,305,769.45 | 550,901,618.94 |
| 210101 | Үндсэн цалин | 280,765,280.64 | 324,212,181.28 |
| 210102 | Нэмэгдэл | 85,975,893.06 | 214,036,157.66 |
| 210104 | Урамшуулал | 40,564,595.75 | 12,653,280.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,532,641.30 | 66,402,483.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,078,975.47 | 45,975,756.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,117,068.74 | 5,502,624.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,289,255.03 | 3,186,213.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 735,850.23 | 2,341,531.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,311,491.83 | 9,396,357.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 61,551,096.59 | 70,614,004.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,246,150.59 | 9,482,596.19 |
| 210302 | Түлш, халаалт | 52,304,946.00 | 61,131,408.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,998,299.14 | 39,551,010.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,401,900.00 | 3,986,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,334,420.00 | 23,287,380.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,253,880.00 | 1,146,450.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 12,494,599.14 | 10,015,280.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 513,500.00 | 1,115,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,163,000.00 | 7,746,540.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,163,000.00 | 7,746,540.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,814,000.00 | 5,838,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,814,000.00 | 5,838,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,052,389.00 | 5,452,507.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 378,800.00 | 2,141,489.98 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | 1,224,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 246,900.00 | 273,825.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 486,790.00 | 370,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 240,000.00 | 143,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,691,899.00 | 1,299,293.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 25,101,257.48 | 57,268,725.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,101,257.48 | 57,268,725.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **740,904,384.80** | **2,505,329,864.52** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,781,400.00 | 23,249,976.68 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 6,157,700.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 14,892,277.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 990,300.00 | 2,199,999.18 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 723,188,432.01 | 2,482,014,711.94 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 723,188,432.01 | 2,482,014,711.94 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 934,552.79 | 65,175.90 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 934,552.79 | 65,175.90 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **614,554,653.00** | **1,735,787,520.83** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **614,554,653.00** | **1,735,787,520.83** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **614,554,653.00** | **1,735,787,520.83** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 614,554,653.00 | 1,735,787,520.83 |
| 220001 | Барилга байгууламж | 347,926,135.00 | 699,131,864.00 |
| 221001 | Их засвар | 00.00 | 120,231,262.83 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 12,750,200.00 | 770,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 14,302,600.00 | 695,103,414.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 239,575,718.00 | 220,550,980.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-614,554,653.00** | **1,735,787,520.83** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,262,355,725.35** | **961,591,451.11** | **1,162,107,616.37** | **3,386,054,792.83** |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,262,355,725.35** | **961,591,451.11** | **1,162,107,616.37** | **3,386,054,792.83** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 869,274.14 | 869,274.14 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,262,355,725.35** | **961,591,451.11** | **1,162,976,890.51** | **3,386,924,066.97** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -869,274.14 | 00.00 | -869,274.14 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 2,350,903,058.09 | 2,350,903,058.09 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,262,355,725.35** | **960,722,176.97** | **3,513,879,948.60** | **5,736,957,850.92** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,238,263,100.00 | 1,863,732,307.21 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 871,907,000.00 | 715,307,962.38 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 861,799,000.00 | 706,950,263.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 608,261,100.00 | 495,847,121.50 |
| 210101 | Үндсэн цалин | 348,068,900.00 | 324,212,181.28 |
| 210102 | Нэмэгдэл | 242,406,900.00 | 158,981,660.22 |
| 210104 | Урамшуулал | 17,785,300.00 | 12,653,280.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 76,748,800.00 | 59,728,619.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,189,100.00 | 41,307,573.12 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,139,900.00 | 4,952,080.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,070,000.00 | 2,908,693.74 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,070,000.00 | 2,106,007.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,279,800.00 | 8,454,264.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 75,260,900.00 | 70,614,004.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,129,500.00 | 9,482,596.19 |
| 210302 | Түлш, халаалт | 61,131,400.00 | 61,131,408.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 37,493,200.00 | 33,479,860.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,506,100.00 | 3,986,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,875,900.00 | 17,216,230.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,200,000.00 | 1,146,450.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 12,500,000.00 | 10,015,280.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,411,200.00 | 1,115,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,099,000.00 | 10,166,540.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | 2,420,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,599,000.00 | 7,746,540.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,962,000.00 | 5,208,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,962,000.00 | 5,208,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,974,000.00 | 13,561,018.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,250,000.00 | 3,250,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,224,000.00 | 1,224,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 350,000.00 | 273,825.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 550,000.00 | 370,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 300,000.00 | 143,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,300,000.00 | 1,299,293.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 32000000.00 | 18345100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,000,000.00 | 18,345,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10108000.00 | 8,357,699.18 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,108,000.00 | 8,357,699.18 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,608,000.00 | 6,157,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,500,000.00 | 2,199,999.18 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,366,356,100.0** | **1,148,424,344.83** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3,366,356,100.0 | 1,148,424,344.83 |
| 220001 | Барилга байгууламж | 372,313,500.00 | 266,878,873.00 |
| 221001 | Их засвар | 227,861,700.00 | 172,525,723.83 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 23,060,000.00 | 22,960,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,743,120,900.0 | 686,059,748.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,238,263,100.0 | 1,863,732,307.21 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 4,238,263,100.0 | 1,863,732,307.21 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 4,238,263,100.0 | 1,863,732,307.21 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24.00 | 20.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 06.00 | 06.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 08.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 06.00 | 04.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **65,048,328.69** | **699,080,079.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **45,448,328.69** | **128,136,903.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 45,448,328.69 | 113,244,626.08 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 27,051,209.96 | 55,054,497.44 |
| 210102 | Нэмэгдэл | 19,164,640.90 | 55,054,497.44 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,289,441.25 | 6,673,863.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,383,244.19 | 4,668,183.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 270,512.09 | 550,543.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 216,409.68 | 277,519.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 45,742.42 | 235,523.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 373,532.87 | 942,092.84 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 00.00 | 6,071,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 6,071,150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 630,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 630,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 891,489.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 891,489.98 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,107,677.48 | 43,923,625.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,107,677.48 | 43,923,625.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 14,892,277.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 14,892,277.50 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 14,892,277.50 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,600,000.00** | **570,943,176.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 19,600,000.00 | 570,943,176.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 220001 | Барилга байгууламж | 00.00 | 509,959,510.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 19,600,000.00 | 60,983,666.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 65,048,328.69 | 699,080,079.58 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 65,048,328.69 | 699,080,079.58 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 83,024,388.60 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 49,828,328.69 | 511,851,099.98 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,220,000.00 | 104,204,591.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөрөнгө оруулалтын зардлаар хийгдэж, улсын комисс хүлээж аваагүй байхад зардалд хааж бичсэн 1,094,386.5 мянган төгрөгийн Спорт заалыг авлагаар тусгуулсан. | 1 | 1,094,386.5 | 1 | 1,094,386.5 | 1 | 1,094,386.5 | | |
| Дүн | 1 | 1,094,386.5 | 1 | 1,094,386.5 | 1 | 1,094,386.5 | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Баян сумын ЕБС-ийн спорт заалны ажлыг хийсэн компанитай 328.4 сая төгрөгийн техник эдийн засгийн үндэслэл, магадлалгүйгээр гэрээ байгуулан үнийн зөрүү өгсөн байна. | 1 | 328,400.0 | | | | | | | 1 | 328,400.0 |
| Баянгийн үдэш арга хэмжээнд 1,204.6 мянган төгрөг, | 1 | 2,593.1 | | | 1 | 2,593.1 | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| спортын уралдаан тэмцээнд 1,388.5 мянган төгрөг, нийт 2,593.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. | | | | | | | | | | |
| ГХБХБГ-ын ирүүлсэн судалгаатай тулган баталгаажуулалт хийхэд нийт 16 газраас 15,007.5 мянган м2 бүхий 8 газрыг данс бүртгэлд тусгаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | |
| Дүн | 3 | 330,993.1 | | | 1 | 2,593.1 | 1 | - | 1 | 328,400.0 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд байршуулах 7 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Нийт дүн | 1 | - | | | | | 1 | - |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn